

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/19/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: [odbilegb@audit.gov.mn](mailto:odbilegb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |
| ЗГУМС    | Засгийн газрын удирдлага мэдээллийн систем                  |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/218

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА С.ДАВААХҮҮ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 87,1 хувь, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 80,54 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж тус тус дүгнэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга тайлант онд түүхт ойн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд иргэдийн санал санаачилгаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 356,219.6 мянган төгрөг, урсгал төсвийн хөрөнгөөр 298,608.2 мянган төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 54,500.0 мянган төгрөг нийт 709,327.7 мянган төгрөгийн ажлыг төлөвлөж, гүйцэтгэлээр 441,767.9 мянган төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал халуун усны газрын их засвар, хог тээврийн машины

шинэчлэл гэр хорооллын айл, өрхийг төвлөрсөн халаалтад холбох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

|       |  | /мянган төгрөгөөр/ |             |             |
|-------|--|--------------------|-------------|-------------|
| Код:  | Тайлангийн үзүүлэлт                                | Тодруулга          | 2022.12.31  | 2023.12.31  |
| 1     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     |                    | 525,611.7   | 787,474.4   |
| 31    | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                              | 3а, 3б             | 186,892.9   | 247,963.0   |
| 33    | <b>АВЛАГА</b>                                      | 5а, 5б, 6а, 6б     | 255,845.6   | 368,453.3   |
| 35    | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                              | 8а, 8б, 8в         | 82,873.2    | 171,058.1   |
| 2     | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 |                    | 5,205,076.9 | 5,052,162.4 |
| 39    | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                              | 12а, 12б, 12в      | 5,205,076.9 | 5,052,162.4 |
| 39200 | Биет хөрөнгө                                       |                    | 5,183,105.4 | 5,030,340.9 |
| 39300 | Биет бус хөрөнгө                                   | 13                 | 21,971.5    | 21,821.5    |
| 3     | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 |                    | 5,730,688.6 | 5,839,636.8 |
| 4     | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              |                    | 34,634.4    | 15,693.8    |
| 41    | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                   | 15а, 15б           | 34,634.4    | 15,693.8    |
| 41300 | Өглөг  | 17а, 17б           | 34,634.4    | 15,693.8    |
| 5     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    |                    | 5,696,054.2 | 5,823,943.0 |
| 51    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 |                    | 5,696,054.2 | 5,823,943.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал                    |                    | 608,018.8   | 608,018.8   |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн                               |                    | 4,729,710.5 | 4,857,895.1 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   |                    | 358,324.8   | 358,029.1   |
| 6     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> |                    | 5,730,688.6 | 5,839,636.8 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

|      |  | /мянган төгрөгөөр/ |             |             |
|------|--|--------------------|-------------|-------------|
| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | Тодруулга          | 2022.12.31  | 2023.12.31  |
| I    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                   |                    | 3,879,491.0 | 2,736,023.9 |
| 11   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                                   |                    | 422,337.5   | 383,797.7   |
| 110  | Орлогын албан татвар                                     |                    | 205,847.2   | 231,346.1   |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          |                    | 216,554.7   | 243,346.1   |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт          |                    | -10,707.4   | -12,000.0   |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   |                    | 66,111.0    | 81,067.2    |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            |                    | 150,379.3   | 71,384.3    |
| 12   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                               | 1а, 1б             | 942,124.3   | 790,513.1   |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              |                    | 942,124.3   | 756,234.3   |
| 122  | Тусламжийн орлого  |                    | 0.0         | 34,278.8    |
| 13   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                     |                    | 2,515,029.1 | 1,561,713.2 |
| II   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                       | 2а, 2б             | 3,468,060.0 | 2,584,443.1 |
| 21   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     |                    | 3,103,599.3 | 2,239,958.6 |
| 210  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   |                    | 1,420,143.2 | 2,219,106.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        |                    | 342,171.0   | 651,649.6   |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           |                    | 46,812.2    | 79,450.2    |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                |                    | 487,871.2   | 105,423.7   |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         |                    | 62,147.4    | 69,525.2    |
| 2105 | Нормативт зардал   |                    | 43,446.9    | 52,252.3    |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        |                    | 8,382.1     | 27,472.5    |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   |                    | 5,540.4     | 11,467.1    |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж |                    | 175,157.5   | 199,257.5   |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          |                    | 248,614.4   | 1,022,608.2 |
| 213  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  |                    | 1,683,456.1 | 20,852.2    |
| 22   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  |                    | 364,460.8   | 344,484.5   |

|     |   |  |              |           |
|-----|---|--|--------------|-----------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)           |  | 411,430.9    | 151,580.8 |
| V   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                 |  | 4,577,830.6  | 22,540.0  |
| VI  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) |  | -4,166,399.7 | 129,040.8 |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

|      |   | /мянган төгрөгөөр/                     |                       |                        |
|------|---|--|-----------------------|------------------------|
| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
| 1    | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 9,905,270.1                            | 0.0                   | 9,905,270.1            |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | -42,816.3                              | 0.0                   | -42,816.3              |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 9,862,453.9                            | 0.0                   | 9,862,453.9            |
| 9    | Тайлант үеийн үр дүн                            | -4,166,399.7                           | 0.0                   | -4,166,399.7           |
| 10   | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 5,696,054.2                            | 0.0                   | 5,696,054.2            |
| 11   | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 5,696,054.2                            | 0.0                   | 5,696,054.2            |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | -856.2                                 | 0.0                   | -856.2                 |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 5,695,198.0                            | 0.0                   | 5,695,198.0            |
| 14   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -295.7                                 | 0.0                   | -295.7                 |
| 19   | Тайлант үеийн үр дүн                            | 129,040.8                              | 0.0                   | 129,040.8              |
| 20   | 2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл            | 5,823,943.0                            | 0.0                   | 5,823,943.0            |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

|      |   | /мянган төгрөгөөр/ |             |             |
|------|---|--------------------|-------------|-------------|
| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Тодруулга          | 2022.12.31  | 2023.12.31  |
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)          |                    | 3,330,093.4 | 2,442,686.1 |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                                 |                    | 422,337.5   | 383,797.7   |
| 110  | Орлогын албан татвар                            |                    | 205,847.2   | 231,346.1   |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                 |                    | 216,554.7   | 243,346.1   |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт |                    | -10,707.4   | -12,000.0   |
| 113  | Хөрөнгийн албан татвар                          |                    | 66,111.0    | 81,067.2    |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                   |                    | 150,379.3   | 71,384.3    |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж                   |                    | 13,027.7    | 9,332.2     |
| 1181 | Газрын төлбөр                                   |                    | 80,689.3    | 50,987.1    |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр                 |                    | 56,662.3    | 11,065.0    |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                             |                    | 372,494.7   | 496,702.7   |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                     |                    | 372,494.7   | 462,423.9   |
| 122  | Тусламжийн орлого                               |                    | 0.0         | 34,278.8    |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                   |                    | 2,535,261.1 | 1,562,185.8 |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН               |                    | 3,006,309.7 | 1,942,231.1 |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                   |                    | 3,006,309.7 | 1,942,231.1 |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                 |                    | 1,320,236.6 | 1,921,378.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил               |                    | 345,377.6   | 658,830.0   |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл  |                    | 45,867.4    | 82,456.0    |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал       |                    | 477,789.4   | 117,678.8   |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                |                    | 39,303.2    | 54,930.9    |
| 2105 | Нормативт зардал                                |                    | 47,423.8    | 68,657.0    |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал               |                    | 16,260.7    | 27,716.0    |
| 2107 | Томиллолт, зочны зардал                         |                    | 5,540.4     | 11,467.1    |

|      |  |  |             |            |
|------|--|--|-------------|------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж |  | 177,571.8   | 307,742.1  |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          |  | 165,102.4   | 591,901.0  |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   |  | 1,686,073.0 | 20,852.2   |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      |  | 323,783.7   | 500,455.0  |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                |  | 453,729.2   | 438,883.9  |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   |  | 453,729.2   | 438,883.9  |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      |  | 453,729.2   | 438,883.9  |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    |  | -453,729.2  | -438,883.9 |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН   |  | -33,406.0   | -501.0     |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               |  | 33,406.0    | 501.0      |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)        |  | -163,351.5  | 61,070.1   |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         |  | 350,244.4   | 186,892.9  |
| 20   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        |  | 186,892.9   | 247,963.0  |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код  | Үзүүлэлт   | Төлөвлөгөө  | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|------|--|-------------|-----------------------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 2,299,531.8 | 2,045,350.2                 |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 1,656,057.1 | 1,627,671.4                 |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 1,636,867.1 | 1,608,481.4                 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 615,612.2   | 610,713.3                   |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 76,951.4    | 76,431.8                    |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 548,344.8   | 533,589.4                   |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 48,638.5    | 47,170.9                    |
| 2105 | Нормативт зардал   | 6,000.0     | 6,000.0                     |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 18,000.0    | 18,000.0                    |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 13,445.3    | 11,467.1                    |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 270,262.7   | 268,666.9                   |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 39,612.2    | 36,442.0                    |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 19,190.0    | 19,190.0                    |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 19,190.0    | 19,190.0                    |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 543,474.7   | 417,177.8                   |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 100,000.0   | 501.0                       |
| III  | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 2,299,531.8 | 2,152,381.3                 |
| 31   | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                  | 342,692.9   | 334,114.0                   |
| 32   | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 1,726,634.0 | 1,769,294.2                 |
| 35   | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                    | 205,204.9   | 14,694.2                    |
| 36   | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ                        | 25,000.0    | 34,278.8                    |
| 6    | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                         | 69.00       | 69.00                       |
| 61   | БАЙГУУЛЛАГЫН ТОО   | 3           | 3                           |
| 62   | АЖИЛЛАГСАДЫН ТОО   | 33          | 33                          |
| 65   | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ                                      | 33          | 33                          |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код  | Үзүүлэлт   | Өмнөх он  | Тайлант он |
|------|--|-----------|------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 111,335.6 | 301,414.9  |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 100,924.3 | 301,414.9  |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 54,604.9  | 258,211.2  |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 0.0       | 48,116.6   |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 0.0       | 6,024.2    |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 1,185.9   | 0.0        |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 1,256.8   | 7,760.0    |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 2,560.7   | 29,399.2   |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,003.9   | 38,589.7   |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 46,597.6  | 128,321.5  |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 46,319.4  | 43,203.8   |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 9,701.6   | 0.0        |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 36,617.8  | 43,203.8   |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 10,411.3  | 0.0        |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 10,411.3  | 0.0        |
| I    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 111,335.6 | 301,414.9  |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 111,335.6 | 301,414.9  |
| III  | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)                 | 0.0       | 0.0        |
| 9    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 0.0       | 0.0        |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 0.0       | 0.0        |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга тайлант онд түүхт ойн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд иргэдийн санал санаачилгаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 356,219.6 мянган төгрөг, урсгал төсвийн хөрөнгөөр 298,608.2 мянган төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 54,500.0 мянган төгрөг нийт 709,327.7 мянган төгрөгийг ажил төлөвлөж, гүйцэтгэлээр 441,767.9 мянган төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал халуун усны газрын их засвар, хог тээврийн машины шинэчлэл, гэр хорооллын айл, өрхийг төвлөрсөн халаалтад холбох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 87,1 хувь, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 80,54 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж тус тус дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/193 захирамжаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга 2021 онд батлагдсан 5 бүлэг бүхий Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108,948.2 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар өссөн байна. *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

| Үзүүлэлт                                 | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | /мянган төгрөгөөр/ |
|--|--------------------|--------------------|--------------------|
|  |                    |                    | Өөрчлөлт           |
| Б  | 1                  | 2                  | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                           | 186,892.9          | 247,963.0          | 61,070.1           |
| Авлага                                   | 255,845.6          | 368,453.3          | 112,607.7          |
| Бараа материал                           | 82,873.2           | 171,058.1          | 88,184.9           |
| Үндсэн хөрөнгө                           | 5,205,076.9        | 5,052,162.4        | -152,914.5         |
| Нийт хөрөнгө                             | <b>5,730,688.6</b> | <b>5,839,636.8</b> | <b>108,948.2</b>   |
| Өр төлбөр                                | 34,634.4           | 15,693.8           | -18,940.6          |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 5,696,054.2        | 5,823,943.0        | 127,888.8          |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн    | <b>5,730,688.6</b> | <b>5,839,636.8</b> | <b>108,948.2</b>   |

*Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 61,070.1 мянган төгрөгөөр өсч 247,963.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Тайлант онд орон нутгийн орлого 112,343.7 мянган төгрөг нь давсан орлогын үлдэгдэл,

орон нутгийн хөгжлийн сан 92,891.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сангийн 26,906.4 мянган төгрөгийн үлдэгдэл, 5,061.0 мянган төгрөгийн Байгаль хамгаалах барьцаа нөхөн сэргээлтийн сангийн үлдэгдэл тус тус нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 368,453.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 112,607.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 121,529.9 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 243,694.4 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 3,229.0 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 171,058.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 88,184.9 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газар 9,735.2 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 80.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 10,404.6 мянган төгрөг, Ойн анги 67,965.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,052,162.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 152,914.5 мянган төгрөгөөр буурсан нь Засаг даргын Тамгын газар 159,187.4 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 300.4 мянган төгрөгөөр буурч, Эмийн эргэлтийн сан 3,637.6 мянган төгрөгийн, Ойн анги 2,935.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй болон худалдан авснаас шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 34,634.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 15,693.8 мянган төгрөг болж 18,940.6 мянган төгрөгөөр буурчээ. Тайлант оны эхэнд Засаг даргын Тамгын газрын 25,279.3 мянган төгрөг, Ойн анги 2,855.1 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 9,986.5 мянган төгрөгийн өглөгтэй байсныг бүрэн барагдуулж, Байгаль хамгаалах сан 6,500.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байснаа 5,750.0 төгрөгөөр бууруулж 750,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон бол Сургууль, Цэцэрлэгийн түлш халаалтын өр буюу 14,943,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 5,823,943.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 127,888.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 247,963.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 61,070.1 мянган төгрөгөөр буюу 32,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт                     | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|------------------|------------------|------------------------|
| Кассад байгаа бэлэн мөнгө    |                  |                  |                        |
| Банканд байгаа бэлэн мөнгө   |                  |                  |                        |
| Төгрөг                       | 186,892.9        | 247,963.0        | 61,070.1               |
| Төрийн сангийн харилцах      | 165,395.1        | 237,202.1        | 71,807.0               |
| Арилжааны банк дахь харилцах | 21,497.8         | 10,760.9         | -10,736.9              |
| <b>Дүн</b>                   | <b>186,892.9</b> | <b>247,963.0</b> | <b>61,070.1</b>        |

Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 247,963.0 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 237,202.1 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 10,760.9 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 237,202.1 мянган төгрөгийн 45,3 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 112,343.7 мянган төгрөг, 37,5 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 92,891.0 мянган төгрөг, 10,9 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 26,906.4 мянган төгрөг, 2,0 хувь буюу Байгаль хамгаалах сангийн 5,061.0 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 71,807.0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оноос Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 92,837.9 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14,193.2 мянган төгрөгөөр өсч, орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 29,474.1 мянган төгрөг, Байгаль хамгаалах сан 5,750.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 10,736.9 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт

1. Лүн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар холбогдох шийдвэргүйгээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад орон нутгийн нэмэгдэл 2,525,2 мянган төгрөг олгосон зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.
2. Лүн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь ичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 3,400.0 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөв.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 368,453.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 112,607.7 мянган төгрөгөөр буюу 30,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт                          | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | /мянган төгрөгөөр/     |
|-----------------------------------|------------------|------------------|------------------------|
|                                   |                  |                  | Өсөлт (+), Бууралт (-) |
| Зээлийн хүүгийн авлага            | 20,525.1         | 22,614.3         | 2,089.2                |
| <b>Байгууллагаас авах авлага</b>  | <b>3,199.3</b>   | <b>124,092.5</b> | <b>120,893.2</b>       |
| <b>Хувь хүмүүсээс авах авлага</b> | <b>232,121.1</b> | <b>221,746.5</b> | <b>10,374.6</b>        |
| <b>Дүн</b>                        | <b>255,845.6</b> | <b>368,453.3</b> | <b>133,357.0</b>       |

Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 243,694.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 66,1 хувийг, байгууллагаас авах Засаг даргын Тамгын газрын авлага 121,529.9 мянган төгрөг буюу 33,0 хувийг, Эмийн эргэлтийн сангийн авлага 3,229.0 мянган төгрөг буюу 0,9 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 368,453.3 мянган төгрөгийн 60,2 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 33,7 хувийг байгууллагаас авах авлага, 6,1 хувийг зээлийн хүүгийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил байхгүй болно.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 171,058.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 88,184.9 мянган төгрөгөөр буюу 106,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт                     | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/     |
|------------------------------|----------------|-----------------|------------------------|
|                              |                |                 | Өсөлт (+), бууралт (-) |
| Түүхий эд материал           | 18,940.1       | 29,344.8        | 10,404.7               |
| Тусгай зориулалттай материал | 2,381.0        | 2,381.0         | 0.0                    |
| Эм боох материал             | 16,559.2       | 26,963.8        | 10,404.6               |
| Хангамжийн материал          | 46,393.1       | 132,713.4       | 86,320.3               |
| Бичиг хэргийн материал       | 4,793.1        | 5,435.8         | 642.7                  |
| Аж ахуйн материал            | 18,273.3       | 41,103.6        | 22,830.3               |
| Сэлбэг хэрэгсэл              | 5,110.0        | 9,462.5         | 4,352.5                |

|                             |          |           |          |
|-----------------------------|----------|-----------|----------|
| Түлш, шатах тослох материал | 0.0      | 0.0       | 0.0      |
| Хүнсний материал            | 0.0      | 0.0       | 0.0      |
| Бусад хангамжийн материал   | 18,216.7 | 76,711.4  | 58,494.7 |
| Мал амьтад                  | 17,540.0 | 9,000.0   | -8,540.0 |
| Дүн                         | 82,873.2 | 171,058.1 | 88,184.9 |

Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга

Бараа материалын үлдэгдэл 171,058.1 мянган төгрөгийн 28,9 хувь буюу 49,401.2 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газар, 2.5 хувь буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 4,343.4 мянган төгрөг, 16.4 хувь буюу Эмийн эргэлтийн сангийн 28,097.8 мянган төгрөг, 52,2 хувь буюу Ойн ангийн 89,215.7 мянган төгрөг эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 285,007.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 204,822.6 мянган төгрөгөөр хасагдсан байна.

**Аудитын илрүүлэлт:** Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил байхгүй болно.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,052,162.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 152,914.5 мянган төгрөгөөр буюу 2,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт                         | /мянган төгрөгөөр/ |                 |                        |
|----------------------------------|--------------------|-----------------|------------------------|
|                                  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Биет хөрөнгө                     | 5,183,105.4        | 5,030,340.9     | -152,764.5             |
| Барилга, байгууламж, орон сууц   | 1,725,250.5        | 1,414,607.0     | -310,643.5             |
| Авто-тээврийн хэрэгсэл           | 483,274.9          | 295,777.9       | -187,497.0             |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 160,746.3          | 68,938.6        | -91,807.7              |
| Тавилга, аж ахуйн эд хогшил      | 73,936.8           | 37,111.7        | -36,825.1              |
| Зам гүүрний байгууламж           | 619,516.1          | 475,136.5       | -144,379.6             |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 0.0                | 0.0             | 0.0                    |
| Бусад үндсэн хөрөнгө             | 3,599,070.9        | 2,432,271.4     | -1,166,799.5           |
| Ном                              | 287,074.8          | 306,497.8       | 19,423.0               |
| Биет бус хөрөнгө                 | 21,971.5           | 21,821.5        | -150.0                 |
| Программ хангамж                 | 1,382.7            | 287.5           | -1,095.2               |
| Бусад биет бус хөрөнгө           | 21,534.0           | 21,534.0        | 0.0                    |
| Дүн                              | 5,205,076.9        | 5,052,162.4     | -152,914.5             |

Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 98,0 хувь буюу 4,950,689.6 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,1 хувь буюу 1,461.3 мянган төгрөгийг ИТХ, 0,1 хувь буюу 3,689.4 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сан, 96,322.1 мянган төгрөг буюу 1,8 хувийг Ойн ангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 5,052,162.4 мянган төгрөг болж, худалдаж авсан 75,805.4 мянган төгрөг, шилжүүлэн авсан 9,058.0 мянган төгрөг, бусад хэлбэрээр авсан 291,613.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, 77,986.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

**Аудитын илрүүлэлт:** 1.Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгийн дүнэ салгаж тайлагнаагүй, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнэ

мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалтай тулгахад 23,917.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулсан.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,449.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,981.1 мянган төгрөгөөр буюу 35,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

| Үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Ажиллагсадтай холбоотой өр       | 2,855.1        | 0.0             | -2,855.1               |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 9,081.8        | 14,943.8        | 5,862.0                |
| Байгууллагад төлөх өр            | 22,697.5       | 750.0           | -21,947.5              |
| Дүн                              | 34,634.4       | 15,693.8        | -18,940.6              |

Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга

Богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл Засаг даргын тамгын газрын 25,279.3 мянган төгрөг, Байгаль хамгаалах сан 5,750.0, Ойн анги 2,855.1 мянган төгрөгийг барагдуулсан байна.

*Аудитын илрүүлэлт: Өмнөх оны ЗДТГ холболтын зургийн үлдэгдэл санхүүжилт 30% болох 9,000.0 мянган төгрөгийг Сонголт дизайн ХХК-д өглөг үүсгэжгүйгээр шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгөв.*

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,823,943.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 127,888.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|----------------|-----------------|------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 608,018.8      | 608,018.8       | 0.0                    |
| Хуримтлагдсан үр дүн  | 4,695,803.6    | 4,857,895.1     | 162,091.5              |
| Өмнөх үеийн үр дүн  | 8,896,110.2    | 4,728,854.3     | -4,167,255.9           |
| Тайлант үеийн үр дүн  | -4,200,306.6   | 129,040.8       | 4,329,347.4            |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 358,324.9      | 358,029.1       | -295.8                 |
| Дүн   | 5,662,147.2    | 5,823,943.0     | 161,795.8              |

Эх сурвалж: Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,857,895.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 162,091.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Лүн сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 857,264.8 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 407,300.2 мянган төгрөг, 2023 оны төсвийн

жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,120,652.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Лүн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар тайлант онд 763,364.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 963,269.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 342,692.9 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 25,000.0 мянган төгрөгөөр, сумын шилжих үлдэгдлийг 105,204.9 мянган төгрөгөөр, нийт 2,199,532.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 9. Орлого эх үүсвэрийн үзүүлэлтүүд

/ мянган төгрөгөөр/

| Орлого, эх үүсвэрийн үзүүлэлтүүд                      | Төсөв баталсан ИТХ-ын тогтоол |                    | Нэмэгдсэн зөрүү  |
|---|-------------------------------|--------------------|------------------|
|   | 2022.12.19 №04                | 2023.08.14 №01     |                  |
| Татварын орлого                                       | 377,226.5                     | 405,864.5          | 28,638.0         |
| Татварын бус орлого                                   | 257,500.0                     | 357,500.0          | 100,000.0        |
| Татварын болон татварын бус орлогын дүн               | <b>634,726.5</b>              | <b>763,364.5</b>   | <b>128,638.0</b> |
| Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 888,918.3                     | 963,269.7          | 74,351.4         |
| Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг    | 273,719.5                     | 342,692.9          | 68,973.4         |
| Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл         | 0.0                           | 0.0                | 0.0              |
| Шилжих үлдэгдэл                                       | 15,000.0                      | 105,204.9          | 90,204.9         |
| Сумын 100 жилийн хандив тусламжийн эх үүсвэр          | 25,000.0                      | 25,000.0           | 0.0              |
| <b>Эх үүсвэрийн нийт дүн</b>                          | <b>1,837,364.3</b>            | <b>2,199,532.0</b> | <b>362,167.7</b> |

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Лүн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Лүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 405,864.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 383,797.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 24,066.8 мянган төгрөг буюу 5,5 хувиар тасалсан байна.

Төв аймгийн Лүн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 284,647.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,220,534.8 мянган төгрөгөөр тодотгон, баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 763,364.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 963,269.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 342,692.9 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 25,000.0 мянган төгрөг, сумын шилжих үлдэгдлийг 105,204.9 мянган төгрөгөөр, нийт 2,199,532.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 963,269.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,045,350.2 мянган төгрөг буюу 88,9 хувьтай байна. Хэмнэгдсэн зардлын 14,1 хувь буюу 28,385.7 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны урсгал зардал, 46,8 хувь буюу 126,296.9 мянган төгрөгөөр хөрөнгийн зардал буюу Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх ажлын гүйцэтгэл гараагүй зардал, 39,1 хувь буюу 99,499.0 мянган төгрөгөөр Хоршоо хөгжүүлэх сангийн зардал тус тус эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын 4 төсөл, 17 арга хэмжээнд 543,474.7 мянган төгрөгийн эх үүсвэр батлагдсанаас гүйцэтгэлээр 417,177.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ                       | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | Зөрүү     | Биелэлт |
|---|---|-------------|-------------|-----------|---------|
| 1 | Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага | 105,396.1   | 104,049.4   | 1,346.7   | 98.7    |
| 2 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 751,245.8   | 734,054.0   | 17,191.8  | 97.7    |
| 3 | Ерөнхий боловсролын сургууль                | 176,499.3   | 175,619.3   | 880.0     | 99.5    |
| 4 | Сургуулийн өмнөх боловсрол                  | 33,524.7    | 31,197.6    | 2,327.1   | 93.1    |
| 5 | Соёлын үйлчилгээ                            | 179,661.2   | 178,983.4   | 677.8     | 99.6    |
| 6 | Эрүүл мэндийн төв                           | 38,223.0    | 35,310.2    | 2,912.8   | 92.4    |
| 7 | Хоршоо хөгжүүлэх сан                        | 100,000.0   | 501.0       | 99,499.0  | 0.5     |
| 8 | Орон нутгийн хөгжлийн сан                   | 445,692.9   | 321,454.9   | 124,238.0 | 72.1    |
| 9 | Ойн анги                                    | 469,289.0   | 464,180.3   | 5,108.7   | 98.9    |
|   | Дүн   | 2,299,532.0 | 2,045,350.2 | 254,181.8 | 88.9    |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 241,635.3 мянган төгрөг, хандив тусламжаар 2,500.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 11,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 46,279.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 258,211.2 мянган төгрөг зарцуулж, Засаг даргын тамгын газар 43,126.7 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 77.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр   | Хэрэгжих хугацаа         | Хүрэх үр дүн                                      | Хэрэгжилтийн явц  | Зарцуулах төсөв   | Зарцуулсан |           |
|---|--|--------------------------|---|---|---|------------|-----------|
| 1 | 70105<br>Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага | 2023.01.01<br>2023.12.31 | Сумын төлөөлөгч, хэсгүүдэд үйлчилгээ              | ИТХ-ын ажлын үзүүлэх  | Сумын төлөөлөгч, ИТХ-ын тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хурлын үйл ажиллагааг тасралтгүй мэдээллээр ханган хэвийн үйл ажиллагааг ханган явуулсан байна. Хэрэгжилт 100% | 105,396.1  | 104,049.4 |
| 2 | 70106<br>Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 2023.01.01<br>2023.12.31 | Гүйцэтгэх засаглалын удирдлага, түүний ажлын алба | Төрийн бодлого шийдвэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэн сурталчлан таниулах үйл ажиллагааг явуулж төрийн албаны үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэж, иргэд, удирдлагуудыг мэдээллээр шуурхай үйлчилж ажилласан байна. Хэрэгжилт 95,6% | 751,245.8   | 656,584.28 |           |

|   |   |                          |  |   |           |            |
|---|---|--------------------------|--|---|-----------|------------|
| 3 | 70106<br>Хоршоо<br>хөгжүүлэх сан            | 2023.01.01<br>2023.12.31 | Хоршооны үйл<br>ажиллагааг дэмжин<br>ажиллах   | Төсөл<br>шалгаруулах<br>зохион байгуулаагүй<br>байна. Хэрэгжилт 0%  | 100,000.0 | 86,838.09  |
| 4 | 71802<br>Ерөнхий<br>боловсролын<br>сургууль | 2023.01.01<br>2023.12.31 | Энэ хичээлийн жилд<br>сурагчдын сурч<br>боловсрох таатай орчин<br>бүрдүүлэн ажиллана   | Хэрэгжилт 100%  | 176,499.3 | 106,933.23 |
| 5 | 71801<br>Сургуулийн<br>өмнөх<br>боловсрол   | 2023.01.01<br>2023.12.31 | БШУЯ-наас гаргасан<br>чиглэлийн дагуу хүүхдийг<br>зайны сургалтад 95%-тай<br>хамруулан агуулгын<br>хоцрогдлыг нөхөн<br>ажиллана. | Мөн багшийн хөгжилд<br>анхааран сургалт<br>зөвлөгөөнд хамруулан<br>ажиллаж боловсролын<br>үнэлгээгээр 98% | 33,524.7  | 41,354.51  |
| 6 | 71702<br>Соёлын<br>үйлчилгээ                | 2023.01.01<br>2023.12.31 | Соёл урлагийн олон талт<br>үйл ажиллагаа болон<br>нийтийн биеийн тамирын<br>үйл ажиллагааг тогтмол<br>зохион байгуулах           | Соёл урлагийн олон талт<br>үйл ажиллагааг<br>сурталчлах ажлыг 3 удаа<br>зохион байгуулан,<br>хэрэгжилт    | 179,661.2 | 17,836.32  |
| 7 | 71602<br>Эрүүл мэндийн<br>төв               | 2023.01.01<br>2023.12.31 | Хэрэгжүүлж байгаа 9<br>хөтөлбөр, 3 бодлогын<br>хүрээнд НЭМ-ийн<br>тусламж үйлчилгээ<br>үзүүлж сургалт<br>сурталчилгаа хийнэ.     | хэрэгжилт 100%-тай<br>байна.  | 38,223.0  | 37,930.98  |
| 8 | 70106<br>Орон нутгийн<br>хөгжлийн сан       | 2023.01.01<br>2023.12.31 | Сумын хөгжлийн<br>хөтөлбөрийн хүрээнд үйл<br>ажиллагааг хэрэгжүүлэх  | ОНХСангийн төсөл<br>хөтөлбөрөөр 8 хөрөнгө<br>оруулалтын ажил, 2<br>хөтөлбөр хэрэгжин<br>ажилласан байна.  | 445,692.9 | 515,825.24 |
| 9 | 71403<br>Ойн анги                           | 2023.01.01<br>2023.12.31 |  |   | 469,289.0 | 464,180.3  |

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх арга хэмжээг 356,219.6 мянган төгрөгөөр, урсгал төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх арга хэмжээг 298,608.2 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр гүйцэтгэх арга хэмжээг 54,500.0 мянган төгрөг нийт 709,327.7 мянган төгрөгийг төлөвлөсөн байна. Тухайлбал Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Нийтийн халуун усны их засвар”-ын ажлыг харьцуулалтын аргаар тендер шалгаруулж Их уул лүн ХХК 69,300.0 мянган төгрөгөөр, гэр хорооллын айл, өрхийг төвлөрсөн халаалтад холбох ажлыг мөн харьцуулалтын аргаар тендер шалгаруулж Алтан сэвсүүл ХХК 99,800.0 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хог тээвэрлэх автомашиныг харьцуулалтын аргаар тендер шалгаруулан 45,000.0 мянган төгрөгөөр тус тус төсөвт өртөгтөө багтаан хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр ажлуудыг шууд худалдан авалтын гэрээ байгуулах, нээлттэй тендер шалгаруулах, харьцуулалтын аргуудыг ашиглан журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгаж ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/91 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 3,879,490.9 мянган төгрөгийг суурь үзүүлэлтээр сонгосон. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар 33,560.4 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа. Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 25,170.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төсвийн нийт зардлыг 254,181.6 мянган төгрөг буюу 11,5 хувиар хэмнэсэн байна. Хэмнэгдсэн зардлын 14,1 хувь буюу 28,385.7 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны урсгал зардал, 46,8 хувь буюу 126,296.9 мянган төгрөгөөр хөрөнгийн зардал буюу Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх ажлын гүйцэтгэл гараагүй зардал, 39,1 хувь буюу 99,499.0 мянган төгрөгөөр Хоршоо хөгжүүлэх сангийн зардал тус тус эзэлж байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Лүн сумын Засаг даргын Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 176 мэдээлэл хугацаанд нь байршуулж, Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн данстай холбоотой зөрчил илрээгүй болно.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нэмэлт санхүүжилттэй холбоотой 1 төлбөрийн акт, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 05/57 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |           | Биелэлт |           |      |
|-----------------|------------------------|-----------|---------|-----------|------|
|                 | Тоо                    | Дүн       | Тоо     | Дүн       | Хувь |
| Акт             | -                      | -         | -       | -         | -    |
| Албан шаардлага | -                      | -         | -       | -         | -    |
| Зөвлөмж         | 2                      | 101,133.8 | 2       | 101,133.8 | -    |
| Нийт дүн        | 2                      | 101,133.8 | 2       | 101,133.8 | 100  |

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Лүн сумын “Түүхт 100 жилийн ой 2024 онд тохиож байгаатай холбогдуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагаас өгсөн хандив тусламжийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд иргэд олон нийтийн саналыг тусгаж эрэмбэлсэн эсэх, гүйцэтгэл, тендер шалгаруулалтай холбоотой асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,066.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 23,146.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Албан шаардлага

##### 1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **Илрүүлэлт:**

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 407,864.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 383,797.6 мянган төгрөг төвлөрсөн ба 16 нэр төрлийн орлогоос 6 нэр төрлийн орлого тасарсан байна. Үүнд хөрөнгийн орлого 6,210.0 мянган төгрөг, малын тоо толгойд ногдуулах албан татвар 15,837.6 мянган төгрөг, газрын төлбөр 9,109.3 мянган төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 7,935.0 мянган төгрөг, түрээсийн орлого 1,715.3 мянган төгрөг, суутган-2 558,5 мянган төгрөг тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэсэн.

## **5.2 Зөвлөмж**

### **Илрүүлэлт:**

1. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр ЗГУМС-тэй тулган баталгаажуулахгүй өр, авлагыг бүрэн тусгаж мэдээлэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил бүтэн жилээр бэлтгэж тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу холбогдох маягтаар гаргуулан авч хянан баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтын дагуу ирүүлж, зөвлөмж болон албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| №           | Төсвийн захирагчийн ангилал             | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|-------------|---|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|             |   | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|             |   |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A           | 1                                       | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1           | Иргэдийн төлөөлөгчдийн хурал            | 1                        |                             | 1                  |                 |                         |                |       |                            |
| 2           | Засаг даргын тамгын газар               | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| 3           | Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан | 1                        |                             | 1                  |                 |                         |                |       |                            |
| 4           | Хоршоо хөгжүүлэх сан                    | 1                        |                             | 1                  |                 |                         |                |       |                            |
| 5           | Эмийн эргэлтийн сан                     | 1                        |                             | 1                  |                 |                         |                |       |                            |
| 6           | Орон нутгийн хөгжлийн сан               | 1                        |                             | 1                  |                 |                         |                |       |                            |
| 7           | Ойн анги                                | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| <b>НИЙТ</b> |   | <b>7</b>                 | <b>2</b>                    | <b>5</b>           |                 | <b>2</b>                |                |       |                            |

**7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| /мянган төгрөгөөр/        |            |                 |                                   |          |                          |                 |            |                 |              |     |
|---------------------------|------------|-----------------|-----------------------------------|----------|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|-----|
| Байгууллагын нэр          | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |          | Буруу тусган илэрхийлсэн |                 | Үүнээс     |                 |              |     |
|                           | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн      | Тоо                      | Дүн             | Залруулсан |                 | Залруулаагүй |     |
|                           |            |                 |                                   |          |                          |                 | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн |
| Засаг даргын Тамгын газар | 2          | 95,722.8        | -                                 | -        | 2                        | 95,722.8        | 2          | 95,722.8        |              |     |
| <b>Дүн</b>                | <b>2</b>   | <b>95,722.8</b> | <b>-</b>                          | <b>-</b> | <b>2</b>                 | <b>95,722.8</b> | <b>2</b>   | <b>95,722.8</b> |              |     |

| /мянган төгрөгөөр/           |             |                  |               |                  |                 |                   |          |                  |     |     |
|------------------------------|-------------|------------------|---------------|------------------|-----------------|-------------------|----------|------------------|-----|-----|
| Байгууллагын нэр             | Нийт зөрчил |                  | Төлбөрийн акт |                  | Албан шаардлага |                   | Зөвлөмж  |                  |     |     |
|                              | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн              | Тоо             | Дүн               | Тоо      | Дүн              |     |     |
|                              |             |                  |               |                  |                 |                   |          |                  | Тоо | Дүн |
| Засаг дарга                  | 2           | 24,066.8         |               |                  | 1               | 24,066.8          | 1        | 0.00             |     |     |
| Засаг даргын Тамгын газар    | 3           | 836,686.9        | 1             | 9,454.2          | 1               | 818,232.70        | 1        | 9,000.0          |     |     |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 3           | 13,925.3         | 1             | 2,525.3          | -               | -                 | 2        | 11,400.0         |     |     |
| Эмийн эргэлтийн сан          | 1           | 305.0            | 1             | 305.0            | -               | -                 | -        | -                |     |     |
| <b>Дүн</b>                   | <b>9</b>    | <b>874,984.0</b> | <b>3</b>      | <b>12,284.50</b> | <b>2</b>        | <b>842,299.50</b> | <b>4</b> | <b>20,400.00</b> |     |     |

